



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/458

Арвайхээр сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны “Хөрөнгө шийдвэрлэх тухай” А/562 дугаар захирамжийн дагуу 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн автомашины дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хөтлөгч: С.Даваадоньд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Б.Эрдэмзаяа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Архив, бичиг хэргийн ажилтан)

Гишүүд: Б.Баттөр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газрын Хууль эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн программ хариуцсан мэргэжилтэн)

2. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (М.Нинжбадгар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0886

D:My Doc. Zahiramj. Zasag darga